



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 16 өдөр

Дугаар A/594

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Буянт багийн нутаг дэвсгэр Хас хороолол 1 дүгээр гудамж 02 б тоотод байрлах Мөнхсүлдийн Баасанжав /ПН73020213/-ийн үйлчилгээний зориулалттай 1003,6 метр квадрат газраас, "Ховдмирас" НҮТББ /1092642/ үйлчилгээний зориулалтаар 800 метр квадрат газрыг Цэцэрлэгт хүрээлэн 1 дүгээр гудамжны 102 тоот болгон 3 жилийн хугацаагаар, үлдсэн 203.6 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 420 метр квадрат болгон, 200 метр квадрат газрыг Мөнхсүлдийн Баасанжав /ПН73020213/-д авто угаалгын зориулалтаар 5 жилийн хугацаагаар, 220 метр квадрат газрыг Мөнхсүлдийн Баасанжав /ПН73020213/-д халуун ус, сауны зориулалтаар 5 жилийн хугацаагаар тус тус шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуйн нэгжид үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/594 Ch
02 02954